



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/488.

Улаанбаатар хот

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 08 дугаар сарын 28-ний өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд нийт 109,154,730.00 (нэг зуун есөн сая нэг зуун тавин дөрвөн мянга долоон зуун гуч) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын ерөнхий нягтлан бодогч (Т.Оюунтуул)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу данс бүртгэлдээ бүртгэн, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж (У.Баатар)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В.Оюумаа* В.ОЮУМАА



1150521900

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 14 дугаар сарын 21-ны өдрийн 488 дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Өмчийн харилцааны газар

№	Эд хогшлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Ашиглалтад авсан он	Нэгж үнэ	Нийт үнэ	Үлдэх өртөг	Эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэн авах байгууллага
1	Суурин компьютер Asus	ш	8	2023	4,070,000.00	32,560,000.00	32,560,000.00	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж
2	Дэлгэц 24 инч	ш	2	2023	648,120.00	1,296,240.00	1,296,240.00		
3	Процессор	ш	2	2023	2,337,500.00	4,675,000.00	4,675,000.00		
4	Принтер олон үйлдэлтэй /өнгөт/	ш	1	2023	862,385.00	862,385.00	862,385.00		
5	Принтер олон үйлдэлтэй /өнгөт/	ш	1	2019	1,149,885.00	1,149,885.00	1,149,885.00		
Тоног төхөөрөмжийн дүн						9,067,890.00	40,543,510.00		
6	Байр зүйн кадастрын цэг тэмдэглэгээний ажил	ш	1	2022	65,531,220.00	65,531,220.00	65,531,220.00	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж
7	Макет	ш	1	2022	3,080,000.00	3,080,000.00	3,080,000.00		
Биет бус хөрөнгийн дүн						68,611,220.00	68,611,220.00		
Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн							109,154,730.00		